



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2018 оны 02 сарын 13 өдөр

Дугаар 37

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. 2017 оны 11 дүгээр сарын кассын орлого 10,810,820 төгрөг байхад кассын орлогыг 10,709,820 төгрөгөөр авч, орлогыг 101,000 төгрөгөөр дутуу бүртгэсэн.

2. Тайлант хугацааны шатахууны зарлагыг тулган шалгахад 659,150 төгрөгийн шатахууны зарцуулалт тодорхой бус, шатахуун олгох зөвшөөрлийн бичиг байхгүй.

3. Жилийн эцсийн тооллогоор 4,445,000 төгрөгийн өртөг бүхий 2 мотор, 75,000 төгрөгийн дрилл дутагдсаныг холбогдох ажилтнаар төлүүлээгүй байхад авлагаар бүртгээгүй.

4. Аудитын явцад ажилтнуудад олгосон цалинг нийгмийн даатгалд мэдээлэгдсэн цалингийн дүнтэй тулган шалгахад 21 хүний цалинг 3,037,356 төгрөгөөр илүү, 64 хүний цалинг 17,711,258 төгрөгөөр дутуу мэдээлсэн.

5. Хэвтэн эмчлүүлэгчдийн гаднаас хэрэглэсэн эмийн үнэнд тайланд онд 4,478,447 төгрөгийг буцаан олгохдоо татварт 447,839 төгрөг суутгаснаас 29,600 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлж, 418,259 төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй байхад түүнийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй.

6. Батлагдсан хуваариар аймгийн Нэгдсэн эмнэлэг 2017 онд 282 орон тоотой байхаар батлагдсан ба гүйцэтгэлээр өмнөх жилд 360, тухайн онд 375 орон тоогоор ажилласан байна. УИХ-ын 67 тоот тогтоолоор төрийн албан хаагчийн үр дүнгийн урамшуулалд 362 хүнээр тооцож 108600.0 мянган төгрөг хуваарилагдсанаас сахилгын шийтгэлтэй 5 хүнээс бусад 360 хүнд ажилласан хугацаанд ногдох 99925.0 мянган төгрөг олгож, тус зардлаас 8675.0 мянган төгрөгийг хэмнэсэн байна. Тус хэмнэлтээс 7581.5 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулж, 1093.5 мянган төгрөгийг оны эцэст төсөвт төвлөрүүлсэн байна.

2517103

Зориулалт бусаар зарцуулсан 7581.5 мянган төгрөгийн 1761.5 мянган төгрөгөөр байгууллагын аварга шалгаруулах 4 төрөлтөт тэмцээн зохион байгуулж, шилдэг ажилтны өргөмжлөлд 220.0 мянга, шагналд 5600.0 мянган төгрөг олгосон зэрэг зөрчлүүд илэрлээ.

Дээрх нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх “Ажил олгогч нь даатгуулагчийн төлбөр зохих нийгмийн даатгалын шимтгэлийг түүнд хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого олгох бүртээ энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр тооцон суутгаж, тухайн сард нь багтаан нийгмийн даатгалын сангийн дансанд шилжүүлнэ”, 17 дугаар зүйлийн 17.1 дэх “ Ажил олгогч ... хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...”, Нийгмийн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь “Ажил олгогчийн буруугаас нийгмийн даатгалын шимтгэл төлөгдөөгүй даатгуулагчид учирсан хохирлыг ажил олгогч бүрэн хариуцаж төлнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь “Бусдад өгөх төлбөр тооцоог зөрүүтэй тооцоолж олгосон”, 3.1.7 дахь “Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан” гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. 2017 оны 11 дүгээр сарын кассын орлогоос дутагдсан 101,000 төгрөгийг кассын нярав С.Буянхишигээр төлүүлэх.

2. Тооллогоор дутагдсан 4445,000 төгрөгийн 2 ширхэг мотор, 75,000 төгрөгийн дрилл зэрэг хөрөнгийг эзэмшиж байсан ажилтнаар төлүүлэх.

3. Зөвшөөрөлгүй олгосон шатахууны 675,150 төгрөг, татварт суутгасан атлаа төсөвт төвлөрүүлээгүй 54,855 төгрөгийг нярав С.Ариунжаргалаар төлүүлэх.

4. Хэвтэн эмчлүүлэгчдийн гаднаас хэрэглэсэн эмийн үнэнд суутгаж төсөвт төвлөрүүлээгүй 363,404 төгрөг, тайлант хугацаанд дутуу мэдээлсэн 64 хүний 17,711,258 төгрөгийн цалинд ногдох нийгмийн даатгалын шимтгэлийн 3,719,364.18 төгрөгийг байгууллагаар төлүүлэх.

5. 2017 онд илүү мэдээлсэн 21 хүний 3,037,356 төгрөгийн цалинг залруулан мэдээлж, зөрүүг арилгах

6. УИХ-ын 67 тоот тогтоолоор олгосон үр дүнгийн урамшууллын зардлаас зориулалт бусаар зарцуулж шагналд олгосон 5150.0 мянган төгрөгийг байгууллагын төсвийн захирагч, нягтлан бодогч нараар төлүүлэхээр тус тус төлбөрийн акт тогтоов.


7. Аудитаар тогтоосон төлбөрийн актыг Төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

8. Төлбөрийн актыг барагдуулсан тухай баримтыг 2018.05.20-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн төсвийн захирагч Н.Баттогтох, ерөнхий нягтлан бодогч Ж.Батжаргал, цалин хөлсний нягтлан бодогч Д.Гантулга нарт хариуцуулав.

АКТ

ТОГТООСОН¹:

АХЛАХ АУДИТОР


Б.ДОЛЖМАА



ЗӨВШӨӨРСӨН:


ТӨСВИЙН ЗАХИРАГЧ


Н.БАТТОГТОХ


ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ


Ж.БАТЖАРГАЛ


НЯГТЛАН БОДОГЧ


Д.ГАНТУЛГА

НЯРАВ


С.АРИУНЖАРГАЛ

НЯРАВ


С.БУЯНХИШИГ

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2018 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 44

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас Баянхонгор аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Баянхонгор сумын ойн хандивт 2017 оны 07 дугаар сард ажиллагсдаас 340.0 мянган төгрөгийг суутгасан атлаа 350.0 мянган төгрөгийг шилжүүлж, 10.0 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн.

2. УИХ-ын 67 тоот тогтоолоор ажилтнуудад олгохоор батлагдсан ажлын үр дүнгийн урамшууллаас хэмнэгдсэн 3710,0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан.

3. 2017 оны 10 дугаар сард "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-д 33.0 мянган төгрөгийг нэхэмжлэхээс илүү шилжүүлсэн атлаа авлагаар бүртгээгүй.

Дээрх нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", УИХ-ын 2017.11.09-ний өдрийн 67 тоот тогтоолоор батлагдсан 1 дэх "2017 оны төсвийн жилд төрийн өндөр албан тушаалтан, шүүгч, прокуророос бусад төрийн албан хаагчдад 300,000 төгрөгийн ажлын үр дүнгийн урамшуулал олгох" зэрэг заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд

2517117

баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь "Бусдад өгөх төлбөр тооцоог зөрүүтэй тооцоолж олгосон", 3.1.7 дахь "Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**



1. Ойн хандивт илүү шилжүүлсэн 10,000 төгрөг, зориулалт бусаар зарцуулсан 3,710,000 төгрөгийг төсвийн захирагч, нягтлан бодогч нараар, илүү шилжүүлсэн 33,000 төгрөгийг "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-аар тус тус төлүүлж, Төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2. Төлбөрийн актыг барагдуулсан тухай баримтыг 2018.05.20-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний газрын төсвийн захирагч Л.Мандал, нягтлан бодогч Э.Амарбаясгалан нарт хариуцуулав.

АКТ

ТОГТООСОН¹:
АХЛАХ АУДИТОР

Б.ДОЛЖМАА
6417143544
Б-0А0067 9007423

ЗӨВШӨӨРСӨН:
ТӨСВИЙН ЗАХИРАГЧ

Л.МАНДАЛ
НЯГТЛАН БОДОГЧ

Э.АМАРБАЯСГАЛАН
641731907
Б-0А0067 9007423

1. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2018 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 51

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Галуут сумын ИТХ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөвлөсөн горим сорилыг хэрэгжүүлэх явцад:

1. Оны эхэнд ажиллагсдаас авах 149.1 мянган төгрөгийн авлагатай байсан ба уг авлагыг барагдуулаагүй атлаа оны эцэст бичилт хийж авлагыг хаасан.

2. 2017 оны 11 дүгээр сард цалингийн цэстээр бодогдсон цалинг олгохдоо Г.Дүүрэнбилэгт 4.5 мянга, О.Амарзаяад 11.5 мянган төгрөг илүү олгосон байна.

Дээрх нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэснийг зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь “Бусдад өгөх төлбөр тооцоог зөрүүтэй тооцоолж олгосон”, 3.1.7 дахь “Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан” гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**



2517131

1. Бичилт хийж хаасан өмнөх оны 149,121 төгрөгийн авлагыг төсвийн захирагч, нягтлан бодогч нараар, илүү олгосон цалингийн 4500 төгрөгийг Г.Дүүрэнбилэгээр, 11500 төгрөгийг О.Амарзаяа нараар тус тус төлүүлж, Төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2. Төлбөрийн актыг барагдуулсан тухай баримтыг 2018.05.20-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Галуут сумын ИТХ-ын төсвийн захирагч Е.Тэргэл, нягтлан бодогч Х.Пүрэвнанзад нарт хариуцуулав.

АКТ

ТОГТООСОН¹:
АХЛАХ АУДИТОР

Б.ДОЛЖМАА
6317143544
БН040067 9007423

ЗӨВШӨӨРСӨН:
ТӨСВИЙН ЗАХИРАГЧ

Е.ТЭРГЭЛ
НЯГТЛАН БОДОГЧ

Х.ПҮРЭВНАНЗАД
ВКА0002

1. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.